



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ

7
АНГИ

ГАЗАР ЗҮЙ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:


САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад хийж гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

1. Экваторын шугамаар дэлхийг ямар хоёр хэсэгт хуваадаг вэ?


- A. зүүн ба өмнөд B. өмнөд ба баруун
C. баруун ба хойд D. хойд ба өмнөд

2. Дэлхийн газар зүйн зургийг ашиглан өмнөд өргөрөг, зүүн уртрагт **бүтнээрээ** орших тивийг сонгоорой.



- A. Хойд америк
B. Австрали
C. Өмнөд америк
D. Ази

3. Р болон Т цэг хэдэн цагийн зөрөөтэй байна вэ?




- A. 6 цаг B. 5 цаг C. 4 цаг D. 3 цаг

4. Жижиг талбай эзэлдэг обьектуудыг тэмдэгтийн аргаар дүрсэлдэг бол доорх өгөгдлүүдээс аль нь тохиромжтой вэ?

- A. сургууль B. нуур C. зам D. намаг

5. Уг гараг нарны аймгийн нарнаас алслагдсан дарааллаараа 5 дугаарт оршдог. Аль гараг болохыг сонгоорой.




- A. Дэлхий
- B. Ангараг
- C. Бархасбадь
- D. Санчир



6. Дэлхийн гадаргын хотгор, гүдгэр хэлбэрт тектоникийн хавтангийн хөдөлгөөн нөлөөлж уул нурууд, тал, нам дор газрууд үүсдэг. Физик газар зүйн зурагт нам талыг ямар өнгөөр дүрсэлдэг вэ?

- A. ногоон
- B. шар
- C. гүн цэнхэр
- D. цэнхэр

7. Доорх зургуудаас галт уул дэлбэрэлтийн нөлөөгөөр үүссэн гадаргын хэлбэрийг сонгоно уу.
/1 оноо/




8. Термометрийн заалтуудыг ажиглан хамгийн их температур хэдэн градус целсийг заасан байгааг сонгоорой.



- A. 45°
- B. 25°
- C. 0°
- D. 110°

9. Дараах уур амьсгалын диаграммыг уншиж 5, 6, 7, 8 дугаар саруудаас хамгийн их тунадас унасыг сонгоорой.



- A. 5-р сар
- B. 6-р сар
- C. 7-р сар
- D. 8-р сар



10. Дараах улс орнуудаас цунамид хамгийн их өртөх магадлалтайг сонгоорой.



A. Парагвай

B. Судан

C. Монгол

D. Япон

11. Дэлхийн хүйтэн бүсэд амьдардаг амьтныг сонгоорой.

A. оцон шувуу

B. хүрэн баавгай


C. сармагчин

D. зээр

12. Ази тивийн хүмүүсийн онцлог төрхийг зөв сонгоорой.

- A. Цагаан арьстай, христийн шашин нийтлэг шүтдэг ч дотроо католик, протестант урсгал хөгжсөн
- B. Угуул нутгийн иргэд нь негржүү хар арьстай, лал болон христийн шашин шүтдэг
- C. Ихэнх хүмүүс нь шар арьстай бөгөөд холимог арьстан ихтэй, будда, хинди, лалын шашин шүтдэг
- D. Угсаатны бүлэг, арьсны өнгө нь холимог, христийн шашин дэлгэрсэн ч индианчууд угуул шашинтай.

13. Далайн урсгалыг хүйтэн болон дулаан гэж ангилдаг. Африк тивийн ойролцоо далайн урсгалуудаас баруун өмнө хэсэгт орших хүйтэн урсгалыг сонгоно уу.




A. Гвинейн урсгал

B. Бенгалын урсгал

C. Канарын урсгал

D. Мозамбекийн урсгал

14. Агаар дахь усны уур хийн төлөвөөс шингэн төлөвт шилжиж, дулаан ялгаруулах усны уурын өтгөрөл буюу конденсацын үзэгдлийг хэдийн тоогоор тэмдэглэсэн байна вэ?




- A. 5
- B. 4
- C. 3
- D. 1

15. Америк тивд орших голуудаас хамгийн том ус цуглуулах талбайтайг нь сонгоно уу.



- A. Маккензи
- B. Миссисипи
- C. Амазон
- D. Парана

16. 3 дугаартай цэгийн уртраг, өргөргийн солбицлыг зөв тодорхойлсныг сонгоно уу.




- A. Хθ450БУ90⁰
- B. Хθ45⁰ЗУ90⁰
- C. Θθ45⁰ЗУ90⁰
- D. Θθ45⁰БУ90⁰

17. Зураг дээрх байгалийн төрх байдал өгөршиж өөрчлөгдхөд ямар хүчин зүйл нөлөөлсөн байна вэ?



- A. Дэлхийн гадаад хүчиний нөлөөгөөр буюу салхиар элэгдэх үйл явцын үр дүн
- B. Дэлхийн дотоод хүчиний нөлөөгөөр буюу усаар элэгдэх үйл явцын үр дүн
- C. Дэлхийн дотоод хүчиний нөлөөгөөр буюу галт уул дэлбэрэх үйл явцын үр дүн
- D. Дэлхийн гадаад хүчиний нөлөөгөөр буюу газар хөдлөлтийн үйл явцын үр дүн

18. Хуурай газрын усны төрлүүдийг дарааллын дагуу зөв нэрлээрэй.



- | | |
|----------------------------------|----------------------------------|
| A. хүрхрээ, гол, нуур, мөсөн гол | B. мөсөн гол, хүрхрээ, нуур, гол |
| C. мөсөн гол, гол, хүрхрээ, нуур | D. нуур, хүрхрээ, мөсөн гол, гол |

19. Улаанбаатар хотоос Ховд аймгийн төв Ховд хот хүртэл 1410 км байдаг бол 1:3000000 масштабтай газар зүйн зурагт хэдэн сантиметрээр зурагдах вэ?

- A. 4,7 см
- B. 47 см
- C. 470 см
- D. 2127 см

20. Дэлхийн ямар уур амьсгалын бүсийг илэрхийлсэн уур амьсгалын диаграмм болохыг зөв тодорхойлсныг сонгоорой.



- A. Эх газрын уур амьсгалын бүс
- B. Туйлын уур амьсгалын бүс
- C. Цөлийн уур амьсгалын бүс
- D. Далай тэнгисийн уур амьсгалын бүс